

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

“ МАНДАЛГОВЬ-ИМПЕКС”ХК-ий ХЭ-гчдийн ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Дугаар 2026/01

Хурал хийсэн огноо: **2026.04.29.**

Хурал хийсэн газар: “Мандалговь-Импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4-р сарын 29-ны 15 цагт УБ хот, БЗД, 6-р хороо, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 57/7 тоот хаягт байрлалтай ажлын байранд

Хурал эхэлсэн хугацаа: **15:15 цаг**

Хурал зохион байгуулах комиссийн дарга **О.Мөнх-Эрдэнэ** эрүүл мэндийн шалтгаанаар Хятад улсад яваа учраас онлайнаар оролцож хурлыг ХЭ-ч **С.Баярцэцэг** нээж тооллогын комиссын дарга **Г.Отгонжаргалд** хурлыг ирцийг мэдээлэв.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн тухай болон хурлыг хүчин төгөлдөрт тооцох тухай Компанийн тухай хуулийн 67-р зүйлийн 67.3.1-дэх заалт, 69-р зүйлийн 69.1-дэх заалтыг тус тус үндэслэн:

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн ээлжит хуралд нийт 71,371 саналын эрх бүхий энгийн хувьцааны 52,642 ширхэг хувьцаа эзэмшдэг хувьцаа эзэмшигчид саналын хуудсаар оролцож нийт саналын 73,76% болж байна.
2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн дүрмийн холбогдох заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 73,76%-ийг эзэмшигчид хуралд саналын хуудсаа бөглөн оролцсон учир компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

С.Баярцэцэг:

Хэлэлцэх асуудал:

“Мандалговь-Импекс” ХК-ий 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны талаарх болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх;
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах
3. 2026 онд шаардагдах төсөв, түүнтэй холбоотойгоор зээл авах тухай

Хурлын дэг:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг хэлэлцэх
2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. 2026 онд шаардагдах төсөв, түүнтэй холбоотойгоор зээл авах
4. Санал, шүүмжлэл
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулах

Хурлын явц:

1. Хэлэлцэх асуудлыг танилцуулж 100% саналаар батлав.

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

2. Хурлын дотоод журам, дэгийг танилцуулахад, санал нэгтгэйгээр батлав. Хэлэлцэж буй асуудалтай холбоотой асуулт, саналаа тухай бүр гаргахаар шийдвэрлэв.

3. Хурлын дэгийн дагуу:

Нэг: Компанийн 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх сонсгол, дүгнэлтийг С.Баярцэцэг танилцуулав.

С.Баярцэцэг: Алтанговь зочид буудлын үйл ажиллагаа зогсолттой, ямарч орлого олоогүй. 2025 онд засварын ажиллагаа явуулж байхад газрын маргаан үүссэн. Тиймээс засварын ажиллагаа бүрэн зогссон. Шүүхийн маргаантай байгаа тул ямар нэгэн үйл ажиллагаа явуулах боломжгүй зогсонги байдалд орсон байна.

Үйл ажиллагаа явуулаагүй ч тогтмол зардлууд болох газар, үл хөдлөхийн татвар, аудит, хөрөнгийн биржийн хураамж, ҮЦТХТ-ийн үйлчилгээний төлбөр, баримт бичиг бүрдүүлэхэд гарч буй зардлыг багахан хэмжээний зээл авч төлж байна. Иймээс 2025 оны хувьцаа эзэмшигчдэд ноогдол ашиг олгохгүй байхаар шийдвэрлэсэн.

Хоёр: Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө С.Баярцэцэг танилцуулав.

С.Мягмарсүрэн: Шүүхийн маргаантай асуудал шийдвэрлэгдэж байж дараа, дараагийн ажлууд хийгдэх юм байна.

С.Баярцэцэг: Тийм, асуудал нэг талдаа гарсаар засварын ажлыг хийлгэж эхлүүлнэ.

Гурав: 2026 онд шаардагдах төсөв, түүнтэй холбоотойгоор зээл авах тухай

С.Баярцэцэг: Засварын үйл ажиллагаа эхлүүлэх нөхцөл бүрдэх үед зээл авах нь зөв.

Дөрөв. Санал шүүмжлэл: Хэлэлцэж буй асуудал тус бүр дээр санал шүүмжлэлээ хэлээд явсан болно.

ХЭ-гчдийн ээлжит хуралын санал авах хуудсыг тарааж өгч, ХЭ-гчид саналаа бөглөв.

Тооллогын комисс Санал авах хуудсыг хураан авч Саналын дүнг танилцуулав.

Тооллогын комиссын ТОГТООЛ дугаар 02-ыг танилцуулав.

Тав: Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцуулав.

Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.9-дэх заалт, 2026 оны 4 сарын 29-ны өдрийн **ТООЛЛОГЫН КОМИССЫН** тогтоолыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг баталсугай.
2. Компанийн 2026 онд хэрэгжүүлэхээр танилцуулсан төлөвлөгөөг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллахыг ГЗ Ц.Одгэрэлд үүрэг болгосугай.
3. 2026 онд “Мандалговь-Импекс” ХК зээл авах, энэ талаарх асуудлыг судалж хуулийн хүрээнд ажиллахыг ГЗ Ц.Одгэрэлд үүрэг болгосугай.
4. Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон үүргээ хэрэгжүүлж, компанийн эрх ашгийн төлөө ажиллахыг гишүүдэд үүрэг болгосугай.

Тэмдэглэл хөтөлсөн:

Д.Одгэрэл